

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2025/032/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24

№

171

танай

ны №

т

ТЭШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн төслийн саналыг 816.6 сая төгрөгөөр өгч 2024 онд төсвийн тодотгол хийн зардлыг 277.5 сая төгрөгөөр нэмж 1094.1 сая төгрөгөөр баталсан байна. Төсөв нэмэгдсэн шалтгаан нь цалин нэмэгдсэн мөн Алтаргана наадмын зардал тусгагдсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1093.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

632502296

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>39,270,537.63</u>	<u>127,594,103.78</u>
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,907,935,684.61	2,486,454,162.60
Нийт хөрөнгийн дүн	<u>1,947,206,222.24</u>	<u>2,614,048,266.38</u>
Нийт өр төлбөрийн дүн	736,500,280.74	736,500,280.74
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,210,705,941.50	1,877,547,985.64
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,947,206,222.24</u>	<u>2,614,048,266.38</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн		2,203,455,219.00
Үйл ажиллагааны зардлын дүн		1,536,613,174.86
Үйл ажиллагааны үр дүн		666,842,044.14
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн		666,842,044.14
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		1,210,705,941.50
Тайлант оны үр дүн		666,842,044.14
Эцсийн үлдэгдэл		1,877,547,985.64
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		1,407,222,883.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		1,344,502,943.00
Үйл ажиллагааны ЦМГ		62,719,940.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ		
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1015161578.60
Урсгал зардал		1015161578.60
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав. Аудитын илрүүлэлт

Илрүүлэлт-1:

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа илэрснээс 60.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,7 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй.

Илрүүлэлт-1

Тамгын дарга дээр интернэтийн давхар зардал гаргаж гэр интернэт цэнэглэсэн.

Шийдвэрлэсэн нь: Таслан зогсоох албан шаардлага

5.3 Зөвлөмж

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс Туулай жилийн аврагад хүндэтгэл үзүүлсэн боловч зориулалт бус зарцуулалт хийсэн

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах журмын 2 дугаар зүйл заалтыг мөрдөж ажиллах.

2. ЗДТГ-ын хөрөнгөөр сонгуулийн самбар хийсэн.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

3. Тэшиг сумын ЗДТГ-ын хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүй.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"

4. Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлс эн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тамгын дарга дээр интернэтийн зардал давхар	1	60.0			1	60.0						

зардал гаргаж гэр интернэт цэнэглэсэн.												
Засаг даргын нөөц хөрөнгөөс Туулай жилийн аваргад хүндэтгэл үзүүлсэн зориулалт бус зарцуулалт хийсэн	1	756.0					1	756.0				
ЗДТГ-ын хөрөнгөөр сонгуулийн самбар хийсэн	1	2000.0					1	2000.0				
Тэшиг сумын ЗДТГ-ын хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүй	1	0					1	0				
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	0				
Дүн	5	2,816.0			1	60.0	4	2,756.0				